# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр Дугаар А/411 Номгон

"Содмонгол групп" ХХК-ний эзэмшил газрын зөрчил арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Содмонгол" (2577739) Шатахуун түгээх станцын зориулалттай 803 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул илүү эзэмшиж буй 197 м2 газарт дуудлага худалдааны анхны үнэ дээр дуудах нэг удаагийн интервалыг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж газрыг нэмж эзэмшүүлж хавсралтаар батлсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Д.Алтангэрэл)-д, эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг "Содмонгол групп" ХХК Баянхонгор аймаг дахь салбар (П.Бямбатогтох)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

621011035

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны
өдрийн А/411 дугаар захирамжийн хавсралт

## ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| д/д | Газар эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Зориулалт | Хаяг | Талбайн хэмжээ /м2/ | Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/ | Нийт талбайн хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Содмонгол групп" ХХК | 2577739 | 6409008114 | Шатахуун түгээх станц | Баянхонгор сум, Номгон 1-р баг, Тээвэрчдийн гудамж-4, 427 тоот | 803 м2 | 197 м2 | 1000 м2 |

______oOo______